аймагт л байдаггүй. Хамтарч ажиллаж ч болно шүү дээ. Аль болох хөдөлгөөнд оруулах л шаардлагатай байна.

Н.Цоож: Та нөхдийн санал бодлыг дэмжиж байна. Уг нь боломжийн материаллаг бааз бидэнд байна. Манай аймагт үйлдвэрлэл хөгжихгүй байна. Хүмүүсийн худалдан авах чадвар муудаад байна. Хэдэн малын ашиг шимээр Дундговийнхон амьдарч байна. Уул уурхай үр дүнтэй ажиллахгүй байна. Иймээс бүх хүн худалдаа эрхлэх сонирхолтой болсон. Худалдаа үйлчилгээний газар хангалттай болоод байна. Үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхөөс өөр аргагүй. Түрээсээ өргөжүүлэхэд онцгой анхаарал тавина. Хүнсний дэлгүүрээ нэгдүгээр давхарт шилжүүлж хойноосоо шууд үйлчлүүлэгч орж гардаг болгоё гэж бодож байна. Агуулахыг 200 саяд бол зээл оролцуулаад авах хүн гарч магадгүй. Гэхдээ арай ч хямд үнэ шүү дээ. Ядаж л 300 саяд зарчихмаар байгаа юм. / Аймаг орон нутгийнхандаа/ ҮХХөрөнгө зуучлалын газар Ремакс-т 520 саяар зарах зар тавиулаад 6 сар болж байна. Авахаар сонирхсон хүн гарахгүй байна. Манай аймгийн зах зээлийг голоод байна. Махны үйлдвэр манай аймагт баригдах янзгүй л байна. Тийм хүн гарвал санал тавина гэж бодож байгаа. Та нөхөд ч гэсэн сураг тавьж байх хэрэгтэй. Компанид ашиг тустай байхаар үйл явдал мэдэгдвэл холбоо барьж байгаарай. Хуралд хүрэлцэн ирж санал бодлоо илэрхийлсэн та нөхдөд баярлалаа. Өгсөн зөвөлгөөг чинь ажил хэрэг болгохын төлөө зүтгэнэ.

Хурлын дарга өөр үг хэлэх хүн гараагүй тул санал хэлэх ажиллагааг дуусгавар болов.

2. Хэлэлцсэн нь:

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай ТУЗ-ийн дарга Н.Буянхүү танилцуулав. ТУЗ-ийн гишүүдийн тоог 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар санал оруулж байна. Өөр саналтай хүн байна уу гэхэд байхгүй гэснээр ТУЗ-ийн гишүүдийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

ТУЗ-ийн хурлаар тооллогын комиссын гишүүдийг Х.Төмөрсумъяа, Б.Ганбаяр, Д.Мөнх-Очир нарын бүрэлдэхүүнтэй байгуулж даргаар нь Д,Мөнх-Очирыг томилсон. Иймд тоологын комисс ажилдаа орохыг ТУЗ-ийн дарга урив.

Тоологын комисс саналын хуудсаар нууц санал хураалт явуулж дүнг нэгтгэн тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

/Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав /